# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЗАМЫН ЗУРАГЛАЛ

*/Мэдээлэл, лавлагаа/*

*Р.Хатанбаатар, А.Пагма, Р.Оргилмаа*

**Худалдан авах ажиллагааны замын зураглал**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг дараах хууль, эрх зүйн актуудын дагуу зохион байгуулж байна. Үүнд:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай Монгол Улсын хууль,
2. Төсвийн тухай хууль
3. Бусад хууль, тогтоомж
4. Тендерийн үнэлгээний заавар,
5. Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам,
6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам,
7. Ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг,
8. Эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийн жишиг баримт бичиг,
9. Бараа нийлүүлэх тендерийн жишиг баримт бичиг,
10. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам,
11. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам,
12. Засгийн газрын худалдан авах ажиллагааны сургалт зохион байгуулах сургалтын байгууллагад тавигдах нийтлэг шаардлага зэрэг болно.

Худалдан авах ажиллагааны газар буюу худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээний хувьд захиалагч байж холбогдох худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэгтэй Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Худалдан авах ажиллагаа нь дараах үе шатуудаар явагддаг. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсвийн төслийн хамт боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, худалдан авах ажиллагааны удирдлага, хяналт шинжилгээний мэдээллийн системд батлагдсан төлөвлөгөөг оруулах,
2. Зохих босго үнээс давсан өртөгтэй худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулах,
3. Худалдан авах ажиллагааны журмыг сонгох /Хэрэв хязгаарлагдмал тендер шалгаруулалт болон шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэх бол үндэслэлийг гаргах/
4. Тендерийн баримт бичиг бэлтгэх,
5. Тендерийн урилгыг олон нийтэд зарлан мэдээлэх,
6. Тендерийг хүлээн авах, нээх,
7. Тендерийг хянах, үнэлэх,
8. Гэрээ байгуулах эрх олгох,
9. Тендер шалгаруулалтын онцгой журам хэрэглэх

## 1. Худалдан авалтын төлөвлөлтийн үе шат

Хуульд заасны дагуу Худалдан авах ажиллагааны газар нь Засгийн газраас баталсан улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээний жагсаалтын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлдэг.

Худалдан авалтын төлөвлөлтийн үйл явцыг Хавсралт 1-д үзүүлэв. Захиалагч нь худалдан авах бараа, ажил үйлчилгээний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн төсвийн хүрээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг нэгтгэн гаргаж, төсвийн төслийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Төсвийн ерөнхийлөн захирагч болон худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөөг баталж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Захиалагч нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

*Төлөвлөлтийн хэрэгжилт*

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 131 дүгээр тогтоолоор Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагаас 2013 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад батлагдсан 357 төсөл, арга хэмжээнээс 80 ажлын зураг төсөл, 15 ажлын техникийн тодорхойлолт, 10 ажлын даалгавар Төсвийн ерөнхийлөн захирагч нараас дутуу ирүүлээд байна.

Барилгын ажлын зураг төслийн экспертизээр батлагдсан хяналтын төсөв өртөг нь Монгол Улсын 2013 оны төсвийн хуулиар батлагдсан төсөвт өртгөөсөө 20 хувиас 2. 5 дахин илүү 38 төсөл арга хэмжээ байна.

Тендерийг 2 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй эсвэл тендерт компани оролцоогүй шалтгаанаар дахин зарлаж байгаа ажлууд олон байна.

Цаашид Төсвийн ерөнхийлөн захирагч нар Барилгын тухай хуулийн 15.2-т “Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно” гэж заасан тул зураг төсөлгүй төсөл арга хэмжээнүүдийг 2014 оны улсын төсөвт тусгахгүй байх, мөн “Барилгын норм ба дүрэм батлах тухай” Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын Сайдын 2012 оны 181 дүгээр тушаалыг мөрдөж эхлэхээс өмнө хуучин Барилгын норм ба дүрмээр хийгдсэн зураг төсөлтэй хөрөнгө оруулалтын арга хэмжээг нэгтгэн, Төсвийн тухай хуулийн 8.4.3-т заасны дагуу жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх шаардлагатай байна.

Өмнөх онуудад хийгдсэн зураг төслийг шинэ Барилгын норм ба дүрмийг баримтлан ажлын өртгийг тооцож ирүүлэх шаардлагатай байна. Тендерийн бичиг баримт боловсруулахад шаардлагатай бичиг баримтууд бүрдсэн үед Үнэлгээний хороо байгуулдаг.

### 2. Үнэлгээний хороо байгуулах

Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсвийн дээд хязгаараас давсан тохиолдолд Захиалагч нь байнгын бус ажилллагаатай үнэлгээний хороо байгуулна. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч оролцуулна мөн үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна гэсний дагуу А3 гэрчилгээтэй хүмүүсийг оролцуулдаг.

Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журмыг баримталдаг. Уг журмын дагуу тендерийн хороо нь сондгой тоотой, саналын тэгш эрхтэй гишүүдтэй байхаас гадна хуульд заасан дээрх шаардлагуудыг хангасан байдаг.

### 3. Худалдан авах ажиллагааны журмыг сонгох

Засгийн газраас бараа, ажил, үйлчилгээ гэсэн ангилал бүрээр баталсан босго үнийг тогтоодог. Энэ босго үнийг тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгон сонгодог. Босго үнэд үндэслэн худалдан авах ажиллагааны журмыг сонгоно. Худалдан авах ажиллагааны журмыг сонгох зарчмыг Хавсралт 2-т үзүүлэв. Харьцуулалтын арга, шууд худалдан авах арга, зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэх бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хэмжээг бараа, ажил, зөвлөх болон зөвлөхийн бус үйлчилгээний ангилалаар тогтоосон байдаг. Үүнд:

1. Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсвийн дээд хязгаар нь барааны хувьд 50 сая төгрөг, ажлын хувьд 80 сая төгрөг, зөвлөхөөс бусад үйлчилгээний хувьд 50 сая төгрөг;
2. Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар нь бараа, зөвлөх болон зөвлөхийн бус үйлчилгээний хувьд 10 сая төгрөг;
3. Зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэж болох төсөвт өртгийн дээд хязгаар 50 сая төгрөг тус тус байна.

### 4. Тендерийн баримт бичиг бэлтгэх

Тендерийн хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулахдаа тухайн ажил, бараа, үйлчилгээний онцлогоос хамааруулан Төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичгийн аль тохирохыг ашиглана.

Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгадаг.

Санхүүгийн чадавхийн дараах үзүүлэлтээс шаардлагатай үзүүлэлтүүдийг тендерийн баримт бичигт тодорхой заана. Үүнд:

1. Харилцагч банкны мэдэгдэл;
2. Тендерт оролцогчийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт;
3. Зөвлөхийн орон тоо, цалин бусад зардлын тооцооны хүснэгт;
4. Тендерт оролцогчийн 5 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй бараа, ажил үйлчилгээний жилийн борлуулалтын талаарх мэдээлэл.

Техникийн чадавхи болон туршлагыг үнэлэх дараах үзүүлэлтүүдээс тохирохыг тухайн тендерийн баримт бичигт тодорхой тусгадаг. Үүнд:

1. Тендерт оролцогчийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар;
2. Сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрэс гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт;
3. Сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд бараа үйлчилгээ, тэдгээрийн үнийн дүн, хугацаа болон худалдан авагчдын жагсаалт, шаардлагатай бол бараа үйлчилгээний гүйцэтгэлийн талаарх өмнөх худалдан авагчдын тодорхойлолт;
4. Тендерт оролцогчдын багаж, техник хэрэгслийн тодорхойлолт, үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмжийн жагсаалт;
5. Чанарын хяналтыг шууд, эсхүл туслан гүйцэтгэх гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх чанарын хяналтын арга хэмжээ;
6. Нийлүүлэх барааны загвар, тодорхойлолт, эсхүл гэрэл зураг, тэдгээрийн үнэн болохыг гэрчилсэн баримт бичиг;
7. Барааны хувьд эрх бүхий байгууллагаас олгосон чанарын гэрчилгээ, үйлдвэрлэгчийн итгэмжлэл багтана.

Захиалагч хуульд заасан босго үнээс дээш өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ зөвлөхийн бус үйлчилгээ, 100 сая төгрөгөөс дээш өртөгтэй зөвлөх үйлчилгээ худалдан авах тендерт оролцогчоос тендерийн баталгаа ирүүлэхийг шаарддаг. Захиалагч тендерийн баталгааны хэмжээг дараах байдлаар тогтоож болно. Үүнд:

1. Тендерт оролцогчийг санал болгож байгаа тендерийнхээ үнийн 1-2 хувиар тооцож баталгаа ирүүлэхийг тендерийн баримт бичигт тусгах
2. Шаардлагатай гэж үзвэл захиалагч өөрөө тендерийн баталгааны хэмжээг тухайн бараа ажил үйлчилгээний төсөвт өртгийн 1-2 хувиар тогтоож тендерийн баримт бичигт тусгах.

**5. Тендерийн урилгыг олон нийтэд зарлан мэдээлэх**

Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлдэг. 10 000 000 001 төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил, 100 000 001 төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээний тендерийн урилгыг олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг хэл дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ гэсний дагуу англи хэлээр хэвлэгддэг сонин хэвлэлд нийтэлдэг. Тендерийн урилгад дараах мэдээллийг тусгадаг. Үүнд:

1. Захиалагч байгууллагын тодорхойлолт,
2. Худалдаж авах бараа, ажил үйлчилгээний товч агуулга,
3. Тендерийн баримт бичиг, бусад мэдээлэл авах тендер ирүүлэх хаяг,
4. Тендерийн баримт бичгийн үнэ,
5. Тендер шалгаруулалтад тавих тусгай шаардлага,
6. Тендер хүлээн авах эцсийн хугацаа,
7. Тендер нээх хугацаа,
8. Гадаадын этгээдийг оролцуулах эсэх,
9. Давуу эрх олгох эсэх.

Боловсруулсан тендерийн баримт бичгийг хэвлэн олшруулах, түгээх буюу тендерийн шалгаруулалтыг зохион байгуулах өртгөөр үнэлж, тендерт оролцохыг сонирхогчдод уг үнээр саадгүй худалддаг. Барааны хувьд 50,0 мянган төгрөг, 1 тэрбум төгрөг хүртэл өртөгтэй ажлын хувьд 100 мянган төгрөг, 100-200 мянган төгрөгийн өртөгтэй ажлын хувьд 200 мянган төгрөг, 10 тэрбум төгрөгөөс дээш ажлын хувьд 300 мянган төгрөг байхаар тендерийн үнийг тогтоодог. Үйлчилгээний хувьд 50 мянган төгрөг байдаг.

Хүснэгт 1. **Тендерийн баримт бичгийн үнийн дээд хязгаар**

| *№* | *Төрөл* | *1 тэрбум төгрөг хүртэлх* | *10 тэрбум төгрөг хүртэлх* | *10 тэрбум төгрөгөөс дээш* |
|---|---|---|---|---|
| 1 | Бараа | 50,000.00 /Таван мянган төгрөг/ | | |
| 2 | Ажил | 100,000.00 /Нэг зуун мянган төгрөг/ | 200,000.00 /Хоёр зуун мянган төгрөг/ | 100,000.00 /Гурван зуун мянган төгрөг/ |
| 3 | Үйлчилгээ | 50,000.00 /Таван мянган төгрөг/ | | |

Тендерийн урилгыг www.e-procurement.gov.mn, www.procurement.gov.mn сайтуудаас харж болохоос гадна, өдөр тутмын хэвлэлийн хэрэгсэлээр түгээж байна.

## 6. Тендер хүлээн авах, нээх

Захиалагч тендерт оролцогчдод тендер бэлтгэж ирүүлэх хангалттай, ижил хугацаа олгоно. Нээлттэй тендер шалгаруулалтын тухайд тендер хүлээн авах эцсийн хугацааг 30 буюу түүнээс дээш хоногоор тогтоож, тендер хүлээн авах эцсийн хугацааг тендер шалгаруулалтыг анх зарлан мэдээлсэн өдрөөс эхлэн тооцдог. Тендер бэлтгэх зорилгоор ажлын талбай үзэх шаардлагатай бол түүнд шаардагдах хугацааг оруулан тооцно.

Тендерт оролцогч нь тендерээ тендерийн баримт бичигт товлосон хугацаанд, дурдсан хаягаар, заасан хэлбэрээр ирүүлэх бөгөөд тендерт оролцогч энэ хугацаанд тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, татгалзах саналаа ирүүлж болно.

Тендерийн урилгад заасан тендер ирүүлэх хугацаанаас хожимдож ирсэн эсхүл тендерийн баримт бичигт зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн тендерийг хүлээж авахгүй бөгөөд хаягаар нь буцаана.

Захиалагч хүлээн авсан бүх тендерийг тендерийн баримт бичигт заасан газар, товлосон хугацаанд нийтийн өмнө нээх бөгөөд тендер нээх хугацааг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 1 цагийн дотор байхаар товлоно. Тендер нээхэд тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд оролцох эрхтэй.

Тендер нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, тендерийг хувилбарт саналтайгаар ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хувилбарт саналын үнэ, мөн тендерт тусгасан үнийн хөнгөлөлт, тендерийн баталгаа ирүүлсэн эсэх, оролцогч өөрийн тендерийг өөрчилсөн, эсхүл татгалзсан тухай мэдээллийг захиалагч зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. Уг тэмдэглэлийг сонирхсон этгээдэд танилцуулна.

Тендер нээх үед тэмдэглэл үйлдэх, уг тэмдэглэлд нээлтэд оролцсон этгээд, төлөөлөгчид гарын үсэг зурах, тэмдэглэлийг сонирхосон этгээдэд танилцуулахаас бусад үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахыг хориглодог. Тендер нээх үед зарлагдаагүй, тэмдэглэлд заагаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийн үнийг үнэлгээ хийхэд тооцохгүй.

Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 45 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна.

## 7. Тендерийг хянах ба үнэлэх

Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараах шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ. Үүнд:

1. Хуульд заасны дагуу Захиалагч тендерийн баримт бичигт заасан ерөнхий нөхцөл, санхүүгийн чадавхи, техникийн чадавхи болон туршлага;
2. Техникийн тодорхойлолт;
3. Тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага.

Дээрх бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үздэг. Харин эдгээр нөхцөлийг хангаагүй бол шаадлагад нийцээгүй гэж үзэн захиалагч уг тендерээс татгалзана. Шаардлагад нийцсэн бүх тендерт үнэлгээ хийнэ. Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна.

Тендерүүдийг харьцуулах зорилгоор Захиалагч худалдан авах зөвлөхийн үйлчилгээнээс бусад бараа, ажил, үйлчилгээний онцлогийг харгалзан өөрийн эдийн засгийн үр ашигт нөлөөлөх хуульд заасан хүчин зүйлсээс аль тохирохыг сонгож, мөнгөөр илэрхийлэн тендерийн үнэ дээр нэмж харгалзан тооцож болно. Энэ нь тендерийн үнийг өөрчлөх үндэслэл болохгүй.

Захиалагч шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлж «хамгийн сайн» үнэлэгдсэн тендерийг шалгаруулахад шалгуур үзүүлэлтүүдийг тендерийн баримт бичигт заасан журмын дагуу ашиглана.

Шаардлагад нийцсэн тендерийг дараах байдлаар харьцуулж үнэлдэг:

1. Тендерийн үнэд арифметик алдаа болон орхигдуулсан жижиг хэмжээний зөрүүг залруулах, үнийн хөнгөлөлтийг харгалзан тендерийн үнийг бууруулах, захиалагч хуульд заасныг үндэслэн үнэлгээний бусад шалгуур үзүүлэлтийг сонгосон бол тэдгээрт харгалзах саналуудыг мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэ дээр харгалзан тооцож тендерийн харьцуулах үнийг тодорхойлно;
2. Давуу эрх олгохоор тендерийн баримт бичигт заасан бол давуу эрх эдлэх этгээдийн ирүүлсэн тендерийн харьцуулах үнэд Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг 10 хувиар, ажил гүйцэтгэх тендерийн үнийг 7, 5 хувиар хийсвэрээр бууруулж тооцон бусад заасан хувь хэмжээгээр тооцно;
3. Бүх тендерийг бага харьцуулах үнэтэйгээс их харьцуулах үнэтэй рүү нь эрэмбэлж хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно;
4. Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер гэж үзнэ;
5. Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад чанар ба үнэлгээний харьцуулалтаар өндөр оноо бүхий тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

*Хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалтыг явуулах*

Хуульд зааснаар Захиалагч нээлттэй тендер шалгаруулалтыг дараах нөхцөлд хоёр үе шаттай явуулж болно: Үүнд:

1. Ажлын цар хүрээ их, төсөвт өртөг өндөртэй болон цогцолбор буюу хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх гэрээ байгуулах шаардлагатай бөгөөд техникийн тэгш бус санал ирэх магадлалтай, эсхүл өгөгдсөн шаардлагыг хангах, ижил хэмжээнд хүлээн зөвшөөрөхүйц хоёр, түүнээс дээш техникийн шийдэл байх боломжтой гэж захиалагч үзсэн;
2. Захиалагч техникийн тодорхойлолтыг урьдчилан тогтоох боломжгүй бөгөөд ажлын цар хүрээг эцэслэн тогтоох, техникийн тодорхойлолт бэлтгэхэд туршлагатай гүйцэтгэгч, нийлүүлэгчээс туслалцаа авах шаардлагатай.

Хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалтыг дараах байдлаар явуулна: Үүнд:

1. Тендерт оролцогч нь техникийн саналаа ирүүлэх бөгөөд түүнийг захиалагч үнэлж, нэмж оруулах тодотгол, өөрчлөлтийг тендерт оролцогчтой тохиролцох;

2. Тодотгол, өөрчлөлт оруулсан техникийн саналыг үндэслэн хийсэн санхүүгийн саналаа тендерт оролцогч ирүүлэх бөгөөд энэхүү тодотгосон саналыг захиалагч үнэлэх.
3. Захиалагч хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалт явуулах тухайгаа тендерийн баримт бичиг болон урилгад заана.

Нээлттэй тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай явуулах үед тендерийн үнэлгээг дараах байдлаар хийнэ: Үүнд:

1. Техникийн саналыг хуульд заасны дагуу шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх;
2. Хуульд заасны дагуу Захиалагч тендерийн баримт бичигт заасан ерөнхий нөхцөл, санхүүгийн чадавхи, техникийн чадавхи болон туршлага, техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлагуудыг хангасан техникийн санал тус бүрийн талаар тухайн оролцогчтой захиалагчийн хэрэгцээг илүү хангасан жишиг техникийн тодорхойлолт бэлтгэх зорилгоор санал солилцох;
3. Санал солилцсоны дараа захиалагч жишиг техникийн тодорхойлолт гаргах;
4. Тендерт оролцогч энэ хуулийн дээрхи жишиг техникийн тодорхойлолтод нийцүүлэн өөрийн техникийн саналыг дахин хянаж, өөрчлөн санхүүгийн саналын хамт ирүүлэх;
5. Захиалагч санхүүгийн саналыг товлосон хугацаанд, нийтийн өмнө нээх;
6. Санхүүгийн саналыг хуульд заасны дагуу үнэлж, гэрээ байгуулах эрхийг «хамгийн сайн» гэж үнэлэгдсэн тендерт оролцогчид олгох.
7. Тендерт оролцогч нь хуулийн зааснаар захиалагчаас тогтоосон жишиг техникийн тодорхойлолтын дагуу өөрийн тендерт өөрчлөлт оруулах боломжгүй гэж үзвэл захиалагч уг тендерээс татгалзах эрхтэй.

**8. Гэрээ байгуулах эрх олгох**

Захиалагч энэ хуульд заасан шаардлага хангасан, “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.

«Хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулахаас татгалзсан, эсхүл «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэлд заасан хугацаанд гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй, эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан заасан нөхцөл үүссэн бол түүнд олгосон гэрээ байгуулах эрхийг захиалагч хүчингүй болгож, удаахь “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд ийм оролцогч байхгүй бол бүх тендерээс татгалзсан тохиолдолд хуульд заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.

Захиалагчаас үл хамаарах шалтгаанаар тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах боломжгүй болсон бол захиалагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гарган, зөвшөөрөл авсны үндсэн дээр уг хугацааг нэг удаа 30 хоногоор сунгаж болно.

Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 29. 4-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянаж, захиалагчийн ирүүлсэн баримт бичиг, мэдээлэл болон бусад тодруулгад үндэслэн шийдвэрлэнэ.

*Бүх тендерээс татгалзах*

Дараах тохиолдолд захиалагч бүх тендерээс татгалзана:

1. Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй;
2. Тендер шалгаруулалтад үнийг урьдчилан тохиролцож оролцсон, өрсөлдөгчөө тендер шалгаруулалтын бодит нөхцөлөөс төөрөгдүүлсэн, тэдэнд дарамт, шахалт үзүүлсэн нь шүүх, эрх бүхий байгууллагаас тогтоогдсон бол;
3. Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн;
4. Гэрээний үнийг төсөвт өртөгт багтаах зорилгоор хийсэн хэлэлцээ амжилтгүй болсон.

Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс хэтэрсэн тохиолдолд захиалагч 5 хүртэлх хувиар хэтэрсэн үнэтэй тендер ирүүлсэн тендерт оролцогчтой гэрээний үнийг төсөвт өртөгт багтаах зорилгоор хэлэлцээ хийх бөгөөд ийнхүү хэлэлцээ хийхдээ захиалагч тендерт оролцогчийн санал болгосон үнийг үндэслэлгүйгээр бууруулахыг шаардахыг хориглоно.

Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч тендерт оролцогчийн өмнө хариуцлага хүлээхгүй.

Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана.

1. Тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах;
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах;
3. Мөн хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах

**9. Тендер шалгаруулалтын онцгой журам хэрэглэх**

Тендер шалгаруулалтыг онцгой журмаар явуулахдаа дараах аргыг хэрэглэнэ:

1. Хязгаарлагдмал тендер шалгаруулалт;
2. Харьцуулалт;
3. Гэрээ шууд байгуулах.

*Хязгаарлагдмал тендер шалгаруулалт*

Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргыг дараах тохиолдолд хэрэглэнэ:

1. Мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, техник, технологи шаардсан нарийн төвөгтэй бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх чадвартай этгээдийн тоо хязгаарлагдмал;
2. Хуулийн шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн эсвэл 5 хүртэлх хувиар хэтэрсэн үнэтэй тендер ирүүлсэн тендерт оролцогчтой гэрээний үнийг төсөвт өртөгт багтаах зорилгоор хийсэн хэлэлцээ амжилтгүй болсон бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг

тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах;

Хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулахдаа захиалагч тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангасан уг гэрээг гүйцэтгэх чадавхитай бүх этгээдэд тендерийн урилгыг нэгэн зэрэг илгээж тендер ирүүлэх тэгш боломжоор хангана.

Хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулахдаа захиалагч www.e-procurement.mn, www.procurement.gov.mn вэб хуудасуудад тендерийн урилгыг нийтэлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангаж байна.

Хязгаарлагдмал тендерийн урилга хуульд заасан мэдээллийг агуулсан байна. Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг тендерийн урилга тараасан өдрөөс хойш 15 буюу түүнээс дээш хоногоор тогтооно.

*Харьцуулалтын арга*

Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь Засгийн газрын тогтоосон босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно.

Харьцуулалтын аргыг дараах байдлаар хэрэглэнэ:

1. техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх;
2. Техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгох.

Үнийн санал ирүүлэх хугацааг урилга илгээсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтооно.

Харьцуулалт амжилтгүй болсноос гэрээ байгуулах эрх олгоогүй бол гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэж болно.

*Гэрээ шууд байгуулах арга*

Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах нөхцөлд хэрэглэж болно:

1. Хуульд заасны дагуу дахин тендер заралсан ч бүх тендерээс татгалзах тохиолдол дахин үүссэн, харьцуулалтын тендер шалгаруулалт амжилтгүй болсон;
2. Оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол;
3. Нэмэлт нийлүүлэлт нь анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол;
4. Нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувь болон энэ хуулийн 8.1.1-д заасан харьцуулалтын босго үнийн аль багаас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол;
5. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол;

6. Хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зарим онцгой эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах шаардлагатай гэж үзсэн бол.

Хуульд заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч зохих шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

Хуулийн дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

**Засгийн газрын худалдан авах ажиллагаа хэрэгжиж байгаа байдлын жишээ**[154]

**Нэг.** Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос Шинээр баригдах орон сууцны 11, 12, 13-р хороолол руу дулааны шугам шинээр тавих, хуучин шугамыг өргөтгөх /Дархан-Уул, Дархан/-ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг 2013 оны 02 дугаар сарын 21-ны өдөр урьсан байна. Тендерийг 2013 оны 4-р сарын 4-ний өдрийн 15 цаг 30 минутаас өмнө өгөгдсөн хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2013 оны 4-р сарын 4-ний өдрийн, 16 цаг 00 минутад нээхийг мэдэгджээ.

Тус тендерт нийт 9 оролцогч компани саналаа ирүүлсэн байна. Тендерийн нээлт 2013 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр болж 1,629,801,361 төгрөгийн үнийн санал ирүүлж, тендерийн бусад шаардлагыг хангасан Альянс Тек ХХК шалгарч, энэ компанид 2013 оны 5 дугаар сарын сарын 24-ний өдөр гэрээ байгуулах эрх олгожээ.

Дээрх тендер зарлагдах, нээх, дүгнэхэд нийт **43 хоног** зарцуулсан байна.

**Хоёр.** Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос Нүүрсний лабораторийн тоног төхөөрөмж /Улаанбаатар/-ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг 2013 оны 02 дугаар сарын 28-ны өдөр урьсан байна. Тендерийг 2013 оны 4-р сарын 1-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө өгөгдсөн хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2013 оны 4-р сарын 1-ний өдрийн, 10 цаг 30 минутад нээхийг мэдэгджээ.

Тус тендерт нийт 5 оролцогч компани саналаа ирүүлсэн байна. Тендерийн нээлт 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр болж 284,990,000 төгрөгийн үнийн санал ирүүлж, тендерийн бусад шаардлагыг хангасан Клаймакс Интернэшнл ХХК шалгарч, энэ компанид 2013 оны 5 дугаар сарын сарын 15-ний өдөр гэрээ байгуулах эрх олгожээ.

Дээрх тендер зарлагдах, нээх, дүгнэхэд нийт **32 хоног** зарцуулсан байна.

[154] Тендерийн урилга, нээсэн, дүгнэсэн байдалтай www.e-tender.mn сайтнаас дэлгэрэнгүй танилцаж болно.

**Хавсралт 1.**

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ



**Хавсралт 2.**

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫГ СОНГОХ